



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 4 сарын 05 өдөр

Дугаар 2/01

Сүмбэр сум

Туслах ажилтан, цагдаагийн дэд ахлагч
У.Батбаярт сахилгын арга хэмжээ авах тухай

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3, “Шүүхийн шинжилгээний байгууллагын сахилгын дүрэм”-ийн 3.5.2, 3.5.3, 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус албаны туслах ажилтан, цагдаагийн дэд ахлагч У.Батбаяр нь удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, албанаас болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан 2 удаагийн арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тул албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах сахилгын арга хэмжээ ноогдуулсугай.

2.Тушаалтай холбоотой цалингийн суутгалыг 2022 оны 1, 2, 3 дугаар сард хийж тооцоо бодохыг нягтлан бодогч цагдаагийн ахлах дэслэгч Ү.УУГАНЦЭЦЭГ/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА  Б.ТӨРБАТ





ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 8/02

Сүмбэр сум

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.2 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Албаны ахлах шинжээч эмч, цагдаагийн хошууч Л.Жаргалтогтохыг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс баталсан албаны даргын ажлын байрны тодорхойлолтонд заасан зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг хангуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, дээд байгууллагаас ирүүлсэн хугацаатай албан бичиг, үүрэг, ажлын чиглэлийг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг ахлах шинжээч эмч /цагдаагийн хошууч Л.Жаргалтогтох/-д даалгасугай.

3. Тушаалыг алба хаагч нарт танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.ТӨРБАТ

